



шувуу ажиглагчдын клубын хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг. Монгол орны жигүүртэн амьтад гэрэл зургийн уралдаанд оролцож буй зургууд болон оролцогчдын тоог Facebook дэх шувуу ажиглагчдын группт нийтлэгдэж буй зургуудаас харж болно. Тиймээс Монголын шувуу ажиглагчдын клубын гишүүдийн санаачлагаар одоогоор хуримтлагдаад байгаа шувуудын фото зургуудыг олны хүртээл болгох, ач холбогдлыг нь улам дээшлүүлэх үүднээс <http://mongolianbirdimages.org/> вэб сайтыг та бүхэндээ зориулан нээж байна.

Бидний гол зорилго бол энэхүү вэб хуудсыг Монгол орны шувуудын гэрэл зургийн мэдээллийн нэгдсэн сан болгоход оршино. Энэ сан маань зөвхөн зурган мэдээлэл бүрдүүлээд зогсохгүй тухайн шувууны зураг дарсан газрын цэгийг газрын зураг дээр давхар харуулдагаараа давуу талтай юм. Монголд авсан шувуудын зургаа хүссэн хүн бүр энд байрлуулах боломжтой. Мөн зургаа ирүүлсэн зурагчдын намтар бүхий зурагтай мэдээллийг Гэрэл зурагчид гэсэн хэсэгт байрлуулах болно. Манай сайтад буй шувуудын зургуудыг ямар нэгэн зорилгоор ашиглахыг хүсвэл зөвхөн зургийн эзэн рүү холбогдож зөвшөөрлийг авна. Учир нь энд байгаа зургуудыг аливаа зорилгоор цаашид дахин ашиглах зөвшөөрөл зөвхөн гэрэл зурагчиндаа хадгалагдаж байгаа болохыг анхаарна уу. Манай сайтад өөрийн авсан шувуудын зургаа байрлуулах эсвэл нэмэлт

мэдээлэл авахыг хүсвэл mongolbirdclub@yahoo.com хаягаар холбогдоно уу. Сайт маань одоогоор онлайн болсон байгаа бөгөөд дэлгэрэнгүй мэдээлэл болон шувуудын зураг, бусад холбогдох мэдээллийг хэрхэн, яаж олж авах талаарх заавар зэргийг вэб ашиглах гэсэн хэсгээс үзнэ үү. Та бүхэнд манай сайт таалагдана гэж найдаж байна.

П.Ганхуяг, Зэрлэг амьтан судлах хамгаалах төв

Эрдэнэсантайн Алтан уул, Гурван баян, Давст нуур орчмын газар нутгийг махчин шувуудыг хамгаалах зорилгоор орон нутгийн хамгаалалтанд авлаа

Монголын зэрлэг амьтан судлах хамгаалах төв нь Эрдэнэсантай сумын Алтан уул, Гурван Баянгийн уулс орчмоор 2000 оноос хойш нөмрөг тас болон бусад махчин шувуудын мониторинг судалгааг тогтмол хийж ирсэн. Судлаачид судалгааны ажил дээрээ түшиглэн энэ нутгийг орон нутгийн хамгаалалтанд авах үндэслэл боловсруулан Эрдэнэсантай сумын Засаг даргын тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн барисан юм.

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн 2013 оны 4 сарын 12-ны өдрийн хурлын 21-р тогтоолоор Төв аймгийн Эрдэнэсантай сумын Алтан уул, Гурван баян, Давст нуур орчмын газрыг орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан байна.

Тус орон нутгийн тусгай хамгаалалттай газарт Эрдэнэсантай сумын өмнөд хэсгийн уулсын хамгийн баруун зах болох Ажинтын үзүүрээс (Оргиоч, Цагаан дэрс нуурууд, Эрээний уулс) хамгийн зүүн зах болох Давст нуур хүртэлх үргэлжилсэн уулс, Алтан уул болон түүний орчмын уулс, Баруун, Дунд, Зүүн баянг багтаагаад Ёлт, Зүрх уул хүртэлх нийт 350 километр квадрат газар нутгийг хамарна.

Монгол орны төв хэсгийн нам болон бэсрэг уулс махчин шувууд үүрлэн үржих тааламжтай орчин болдог. Эрдэнэсантад хийсэн судалгааны явцад 12 багийн 111 зүйл шувууд бүртгэгдсэн байна. Мөн энэ нутагт 6 багийн 29 зүйл хөхтөн, 1 багийн 2 зүйл мөлхөгч 1 багийн 1 зүйл хоёр нутагтан бүртгэгдсэн байна. Ургамалжилтын хувьд ерөнхийдөө хуурай хээрийн ургамал зонхилох боловч газрын өндөршлөөс хамаарч бусад бүлгийн ургамал таарна.



Манай оронд суурин үрждэг махчин шувууд Эрдэнэсантын уулсаар харьцангуй элбэг бөгөөд үүрлэж өндөглөдөг 9 зүйлийн түгээмэл махчин шувууд байдаг. Үүнд ооч ёл, цармын бүргэд, нөмрөг тас, идлэг шонхор, сохор элээ, шилийн сар, хээрийн бүргэд, начин шонхор, эгэл шаршувуу орно. Нөмрөг тасын хувьд үржлийн томоохон популяци байдаг ба нийтдээ 40 гаруй үүр тогтмол судалгаанд хамрагддаг байна.

Г.Амархүү, Зэрлэг амьтан судлах хамгаалах төв

Хиймэл үүрэнд бойжсон идлэг шонхорын *Falco cherrug* ангаахай бүрийг өнгөт бөгжөөр тэмдэглэнэ

Монголын Байгаль орчин аялал жуулчлалын яам (хуучнаар) болон Абу Дабигийн Байгаль орчны хөгжлийн агентлаг хооронд байгуулсан санамж бичгийн хүрээнд хэрэгжиж буй хиймэл үүрэнд түшиглэсэн идлэг шонхорын хамгааллын менежментийн хөтөлбөрийн хүрээнд зүүн бүсийн 5 аймгийн 20 сумын нутагт 5000 хиймэл үүр байрлуулаад байгаа билээ. Эдгээр хиймэл үүрэнд үүрлэж байгаа идлэг шонхорын хосуудын тоо жил бүр нэмэгдэж байгаа бөгөөд 2014 онд 2500 ангаахайн амжилттай бойжин ниссэн.

Идлэг шонхорын судалгаанд 2013 оноос ангаахайн нүүдэл шилжилт, мэнд үлдэлтийг судлах зорилгоор өнгөт бөгжийг ашиглаж эхэлсэн. Өнгөт бөгж нь шувуундаа ямар нэгэн сөрөг нөлөөгүй, хөлийг нь барьж боохгүй төдийгүй алсаас харагдац сайтай зэрэг давуу талтай. Өнгөт бөгж нь хуванцар материалаар хийгдсэн бөгөөд харьцангуй уян хатан, өөр дээрээ 1 үсэг, 0-99 гэсэн ахин давтагдахгүй дугаартай, холбоо барих хаягтай. Өндөгнөөс хагарсан ангаахайг ойролцоогоор 3-4 долоо хоногийн настай байхад нь бөгжлөх бөгөөд энэ үед ангаахай үүрнээсээ амжилттай нисэх эх суурь нь бүрэн тавигдсан байдаг гэж судлаачид үздэг. Өнгөт бөгж зүүснээр хиймэл үүрэнд бойжиж байгаа шонхорын үхэл хорогдол, үржлийн дараах шилжилт хөдөлгөөний тухай нарийвчилсан мэдээ цуглуулах боломжтой болох юм. Хэрэв энэхүү бөгжтэй шувуудыг хаа нэгтээ олж харсан, үхсэн байдалтайгаар олсон тохиолдолд та бүхэн бөгж дээрх холбогдох хаягаар бидэнд мэдэгдэнэ үү.

Идлэг шонхорын хиймэл үүрэнд 2013 онд нийт 548 хос идлэг шонхор үүрлэсэн бөгөөд 2000 ангаахайг цагаан дэвсгэртэй бөгжөөр бөгжилсөн бол 2014 онд нийт 720 хос идлэг шонхор хиймэл үүрэнд үүрлэж

